

Дамчаабадгарын Содномжамц<sup>1,✉</sup>, Басандоржийн Буян-Орших<sup>2</sup> Нацагийн Батболд<sup>3</sup><sup>1</sup>Жилиний их сургуулийн Археологийн сургууль, Чянжин гудамж,  
Чанчунь хот, Жилин муж-2699, БНХАУ<sup>2</sup>Өвөр Монголын Их Сургуулийн Монгол судлалын сургууль,  
Их сургуулийн гудамж, Хөх хот, ӨМӨЗО, БНХАУ<sup>3</sup>Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн Археологийн хүрээлэн,  
Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайвны өргөн чөлөө,  
Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр

## Увс аймгийн нутгаас шинээр илрүүлсэн буган хөшөөд

**Товчлол.** Энэхүү өгүүлэлд 2022 оны хээрийн судалгааны явцад Увс аймгийн Малчин, Өмнөговь, Сагил, Тариалан, Ховд, Хяргас зэрэг сумдын нутгаас шинээр илрүүлсэн 21 тооны буган хөшөөний тархалт, дүрслэлийн онцлогийн талаар өгүүлжээ. Евроазийн тал нутагт хүрлийн хожуу үе буюу НТӨ XIII-VII зууны үед өргөн тархсан гайхамшигт нэгэн дурсгал бол буган хөшөө бөгөөд дайчин баатар эрийг төлөөлүүлэн дүрсэлсэн чулуун хөшөө мөн болохыг ихэнх судлаачид дэмжсэн байдаг. Монголын баруун хойд бүс нутагт сүүлийн жилүүдэд археологийн судалгаа өргөн хүрээтэй хийгдсэний үр дүнд шинээр олон тооны буган хөшөөд илэрч олдож буй бөгөөд бид өмнөх судалгааны хэрэглэгдэхүүнийг шинэ материалаар нэмж баяжуулах, зарим онцлог дүрслэлийг дэлгэрэнгүй тайлбарлахыг зорьсон болно.

**Түлхүүр үг:** Буган хөшөө, хүрлийн хожуу үе, зосон будаг, зэр зэвсэг

Sodnomjamts Damchaabadgar<sup>1,✉</sup>, Buyan-Orshikh Basandorj<sup>2</sup>, Batbold Natsag<sup>3</sup><sup>1</sup>School of Archaeology, Jilin university,  
No:2699 Qianjin Street, Changchun city, Jilin province, China<sup>2</sup>School of Mongolian Studies, Inner Mongolia University,  
No:235 Daxue West road, Hohhot, Inner Mongolia, China<sup>3</sup>Institute of Archaeology,  
Mongolian Academy of Sciences Building-1.  
Peace avenue, Ulaanbaatar-13330, Mongolia

## The newly discovered deer stones from the Uvs aimag

**Summary.** Deer stone is a depiction of elegant artistic illustrations of deer and other animals and that was widespread throughout Mongolia and neighboring regions during the Late Bronze Age (13th-7th century BC). In recent years, as a result of extensive archaeological investigation in the northwestern region of Mongolia, a large number of new deer stones were discovered, which expands distribution and density of deer stones and provides new materials and insights into culture's social understandings. In this article, we discussed 21 newly discovered deer stones that were found from the Uvs aimag in 2022. The Deer stone site Ivgeel contains the most number of deer stones in this region and the 4th deer stone stands in the center is taller than others and depicts numerous images, which might have been dedicated to the most high-status person. Moreover, it has revealed ochre paintings on carved images which are rarely encountered on deer stones.

**Keywords:** Deer stone, Late Bronze Age, ochre painting, weapons

### Удиртгал

Монгол орны баруун хойд хэсэгт орших Увс аймгийн нутаг нь эртний нүүдэлчдийн үлдээсэн түүх, соёлын дурсгалаар арвин баялаг бөгөөд түүний нэгээхэн хэсэг нь хожуу хүрлийн үеийн уран гоё, сүрлэг сайхан дурсгал болох буган хөшөө юм. Увс аймгийн нутгаас нийт 54 буган хөшөө бүртгэгдэж судалгааны эргэлтэд орсон байдаг ажээ. Сүүлийн жилүүдэд хайгуул судалгааны ажлын үр дүнд шинэ дурсгалууд илэрч мэдэгдсээр байна. Үүний нэг илрэл болох шинээр олдсон буган хөшөөд буюу 2022 онд Баруун бүс нутгийн чулуун соёлын өвийг шинэчлэн бүртгэх төсөл, Монгол Германы хамтарсан MAPSS төсөл болон Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын авран хамгаалах хайгуул судалгааны ажлын явцад Увс аймгийн Малчин, Өмнөговь, Сагил, Тариалан, Ховд, Хяргас зэрэг 6 сумдын нутгаас шинээр илрүүлсэн нийт 21 тооны буган хөшөөний талаарх судалгааны үр дүнг нэгтгэн хэвлүүлж байна (Зураг 1).

### Судалгааны тойм

Увс аймгийн нутагт хийгдсэн буган хөшөөний судалгааны тоймоос үзэхэд анх Оросын судлаач В.В.Волков 1980-аад онд Увс аймгийн Хяргас сумын Ширэгийн хөндийд 3, Өргөн ширэгт 1, Өндөрхангай сумын Зүүн голд 1 нийт 5 буган хөшөөг бүртгэн баримтжуулснаар тус бүс нутаг дахь уг дурсгалын судалгаа эхэлсэн түүхтэй [Волков 2002: 184]. Түүний дараа 1989 онд “Увс аймгийн археологийн дурсгалын зураг зохиох шинжилгээний анги”-ийн судлаачид Увс аймгийн Тариалан сумын Лойлонгийн аманд 2, Огзомын эхэнд 1, Өмнөговь сумын Бор хагт 1, Түргэн сумын Дэлгэрмөрөн бригадын төвд 1, Ховд сумын Цахир ууланд 1, Бөхмөрөн сумын Наран хөдөөд 1, Баадайн аманд 2 буган хөшөө [Цэвээндорж нар 1989: 297-371] бол дараа жил буюу 1990 онд Өндөрхангай сумын Зүүн голын холбоо толгойд 2, Устад 1, Модотын аманд 1 нийт 13 буган хөшөө тус тус бүртгэсэн байна [Энхбат 1990: 105-144]. 2013 онд археологич Ж.Баярсайхан Увс аймгийн Бөхмөрөн сумын Наран хөдөө, Баадайн амны буган хөшөөдийг шинэчлэн баримтжуулж “Баруун Монголын нутаг дахь зарим буган хөшөөд” нэртэйгээр дахин судалгааны эргэлтэд оруулсан бөгөөд Баадайн амны 1, 2-р буган хөшөөний сэлмийн дүрслэл судалгааны чухал хэрэглэгдэхүүн болохыг онцлон өгүүлжээ [Баярсайхан 2015: 30]. Мөн 2014 онд М.Нямбат, Ц.Одбаатар нар Увс аймгийн Зүүнхангай сумын нутагт буй 13 буган хөшөө [Нямбат нар 2010: 57], 2016 онд Ж.Баярсайхан, Б.Буян-Орших нар Увс аймгийн Өмнөговь сумын нутагт буй 6 буган хөшөөг тус тус судалгааны эргэлтэд оруулжээ

[Баярсайхан, Буян-Орших 2016: 20]. Харин 2021 онд “Монгол ба бүс нутгийн буган хөшөөний соёл” хэмээх томоохон бүтээлд Увс аймгийн нутгаас тухайн үеийн байдлаар илэрч мэдэгдээд байсан нийт 54 буган хөшөөний эрдэм шинжилгээний товч тодорхойлолтын хамт нийтэлжээ [Баярхүү, Энхбаяр 2021: 76-111].

### Увс аймгийн нутгаас

#### шинээр илрүүлсэн буган хөшөөд

**Цалгарын буган хөшөө:** Увс аймгийн Малчин сумын төвийн урд хөндийд хүрлийн хожуу үеийн олон тооны булш оршуулгын дурсгал байрлахын зэрэгцээ эдгээрийн дунд Түрэгийн тахилын байгууламжид хашлага болгон ашигласан нэгэн буган хөшөө байна. Цайвар шаргал өнгийн боржин чулуугаар хийсэн ба хөшөөний дээш харсан хэсэг буюу нүүрэн талд 3 ширхэг ташуу зураас, зууван дугуй хонхор хэлбэрийн хүзүүний зүүлт хөшөөний орой хэсгээр тойруулан толгойн боолт зэргийг тус тус дүрсэлжээ. Хөшөөний өндөр 100 см, өргөн 30 см хэмжээтэй (Зураг 2а).

**Өндөр мөргөний буган хөшөө:** Увс аймгийн Малчин сумын төвөөс зүүн урагш 20 км зайд Хөтөл нуурын Өндөр мөргөн хэмээх газарт 33 метрийн голч бүхий дугуй хүрээтэй хиргисүүрийн голын овоолго дараас чулууны зүүн талд нэгэн буган хөшөө газарт булагдсан байдалтай байна. Цайвар шаргал өнгийн боржин чулууг засаж хийсэн ба хөшөөний орой хэсгээр тойруулан толгойн боолт, нүүрэн талд 3 ташуу зураас, дугуй хэлбэрийн хүзүүний зүүлт, бөмбөлөг хэлбэрийн толттой, хөндлөн балтаг бүхий чичлүүр хутга, баруун болон зүүн талд унжлагатай цагариг хэлбэрийн ээмэг зэргийг тус тус дүрсэлжээ. Хөшөөний өндөр 85 см, өргөн 31 см, зузаан 31 см хэмжээтэй (Зураг 2б).

**Цорготын сайгийн буган хөшөө:** Увс аймгийн Өмнөговь сумын нутаг Алтанхөхий уулын баруун бэл Ховд голын хөндийд Түрэгийн тахилын байгууламж дээр нэгэн буган хөшөө унасан байдалтай байна. Тус хөшөөг Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын авран хамгаалах хайгуул судалгааны явцад анх илрүүлжээ [Эрэгзэн нар 2022: 605]. Буган хөшөөг хар саарал өнгийн хайрган чулуугаар хийсэн ба нүүрэн талд гурван ташуу зураас, хүзүүний зүүлт, зээтүү зэргийг дүрсэлжээ. Хөшөөний өндөр 63 см, зузаан 14 см, өргөн 23 см хэмжээтэй (Зураг 3а).

**Хөх харгайтын (V) буган хөшөө:** Увс аймгийн Сагил сумын нутаг Бага Дөш уулын ар шил Хөх харгайт хэмээх газарт Чандмань-Сагилын соёлд хамаарах бүлэг оршуулгын газар бий. Энэхүү оршуулгын газрын дунд талд буй булшны хүрээний захад босоо байдалтай нэгэн буган хөшөө байна. Өмнөх судалгааны бүтээлд тус

газарт нийт 4 ширхэг буган хөшөөг бүртгэсэн [Баярхүү, Энхбаяр 2016: 105-106] бөгөөд бид тус хөшөөг Хөх харгайт-V хэмээн нэмж бүртгэв. Тус буган хөшөөг хөх саарал өнгийн хайрган чулуугаар хийсэн ба хожим булшны хүрээ чулуу болгон ашиглажээ. Буган хөшөөний нүүрэн талд 3 ширхэг ташуу зураас, хөндлөн балтагтай шулуун мөртэй хутга, баруун болон зүүн талд цагариг хэлбэрийн ээмэг, бүс, зээтүү зэргийг дүрсэлжээ Хөшөөний өндөр 65 см, өргөн 24 см, зузаан 23 см хэмжээтэй. (Зураг 2с).

**Халхайтын дэнжийн буган хөшөөд:** Увс аймгийн Тариалан сумаас баруун зүгт шулуунаар 18 км зайд Хархираа Түргэний уулсын дунд Хархираа голын хойд дэнж дээр сагсай хэлбэрийн булш, хиргисүүр, буган хөшөө, Чандмань-Сагилын булш, төмөр хайлуулах зуух, тахилын байгууламж, хүн чулуун хөшөө зэрэг хүрлийн үеэс Түрэгийн үе хүртэлх түүхийн олон цаг үед холбогдох археологийн цогцолбор дурсгалт газар байдаг. Бид тус дурсгалт газарт нийт гурван буган хөшөөг илрүүлэн бүртгэв.

**1-р буган хөшөө:** Түрэгийн үеийн зэрэгцээ орших гурван тахилын байгууламжийн баруун захад нэгэн буган хөшөөг толгой хэсгийг нь доош харуулан хөшөө чулуу болгон босгожээ. Тус буган хөшөөг хөх саарал өнгийн чулуугаар хийсэн ба дээд хэсгээрээ эмтэрч хугарчээ. Хөшөөний орой хэсгээр тойруулан өргөн ховил бүхий толгойн боолт, хажуу талд унжлагатай цагариг хэлбэрийн ээмэг, дугуй хонхор дүрсээр хүзүүний зүүлт зэргийг тус тус дүрсэлсэн байна. Харин хөшөөний дунд хэсэгт нарийн зураасаар хоёр давхар бүс дүрсэлсэн нь өвөрмөц бөгөөд бүснээс зээтүү, хөндлөн балтагтай чинжаал хутга, хөвчилсөн нум зэргийг зүүжээ. Хөшөөний өндөр 100 см, өргөн 35 см, зузаан 40 см (Зураг 2д).

**2-р буган хөшөө:** 1-р буган хөшөөнөөс зүүн зүгт 5 км орчим зайд Хархираа голын хойд дэнж дээр цацраг бүхий дугуй хүрээтэй хиргисүүрийн чулуун дараасны хажууд нэгэн буган хөшөө тал хэсэг нь газарт булагдсан байдалтай бий. Тус хөшөөний нүүрэн талд гурван ташуу зураас, түүний доод талаар тойруулан дугуй хэлбэрийн хүзүүний зүүлт, хээ чимэглэлгүй нарийн зураасан бүс дүрсэлсэн ба урд талд бүснээс хутга, хажуу талд зээтүү зүүсэн болох нь тодорхой мэдэгдэнэ. Хөшөөний өндөр 102 см, өргөн 30 см, зузаан 13 см хэмжээтэй. (Зураг 2е).

**3-р буган хөшөө:** Хархираа голын хойд эрэгт 300 х 200 см хэмжээтэй дөрвөлжин хашлага бүхий 4 ширхэг тахилын байгууламжийн баруун талын захад улаан хүрэн өнгийн хүрмэн чулуугаар хийсэн нэгэн хүн чулуу хугарсан байдалтай оршино. Тус хөшөөн дээрх дүрслэлийг нарийн ажиглавал буган хөшөөг хожим хүн чулуу болгон

дахин ашиглажээ. Дүрслэлийн хувьд нүүрэн талд хоёр ташуу зураас, хажуу талд унжлагатай цагариг хэлбэрийн ээмэг мэдэгдэнэ. Хөшөөний өндөр 108 см, өргөн 37 см, зузаан 18 см хэмжээтэй (Зураг 2ф)

**Шивэрийн үүдний буган хөшөө:** Увс аймгийн Ховд сумын нутаг Шивэрийн үүдэн хэмээх газарт дугуй хүрээтэй хиргисүүрийн зүүн урд, хүрээ чулууны гадна талд булагдсан байдалтай нэгэн буган хөшөө бий. Газарт ил харагдах хэсэгт бүс, толгойн боолт зэрэг дүрслэл мэдэгдэнэ (Зураг 3б).

**Хусны эхний буган хөшөө:** Увс аймгийн Ховд сумын Шивэрийн голын хөндийд орших Хусны эхэн хэмээх газарт дугуй хүрээтэй хиргисүүр дээр нэгэн буган хөшөө байна. Улаан хүрэн өнгийн боржин чулуугаар хийсэн ба хөшөөний нүүрэн талд гурван ширхэг ташуу зураас, зууван дугуй хэлбэрийн хүзүүний зүүлт, бөмбөлөг толгтой, хөндлөн балтаг бүхий хутга зэргийг тус тус дүрсэлжээ. Хөшөөний өндөр 70 см, өргөн 30 см, зузаан 30 см хэмжээтэй (Зураг 4).

**Ивгээл - I хиргисүүрийн буган хөшөөд:** Увс аймгийн Ховд сумын Ачит нуур багийн нутагт хамаарах Хархираа Түргэний уулсын баруун хормой дахь Ивгээл хэмээх газарт 21 х 19 метр дөрвөлжин хүрээтэй, гол хэсэгтээ 12 метрийн голчтой чулуун овоолго бүхий хиргисүүр бий. Тус хиргисүүрийн хүрээ чулууны зүүн урд талд эгнүүлэн босгосон 5 буган хөшөө, 2 дүрслэлгүй чулуун хөшөө байна.

**1-р буган хөшөө:** Тус буган хөшөө нь энд байрлах 7 хөшөөний хамгийн хойд захад байрлана. Саарал өнгийн боржин чулуугаар хийсэн ба нүүрэн талд гурван ширхэг ташуу зураас дүрсэлсэн. Хөшөөний өндөр 17 см, өргөн 18 см, зузаан 15 см хэмжээтэй (Зураг 5а).

**2-р буган хөшөө:** Улаан өнгийн боржин чулуугаар хийсэн ба нүүрэн талд гурван ширхэг зураасыг хөндлөн байдлаар дүрсэлсэн. Хөшөөний өндөр 32 см, өргөн 23 см, зузаан 17 см хэмжээтэй (Зураг 5б).

**3-р буган хөшөө:** Саарал өнгийн боржин чулуугаар хийсэн ба 1-р хөшөөний адил нүүрэн талд гурван ширхэг ташуу зураас дүрсэлсэн. Хөшөөний өндөр 26 см, өргөн 40 см, зузаан 14 см хэмжээтэй (Зураг 5с).

**4-р буган хөшөө:** Тус буган хөшөө нь энд орших хөшөөдийн голд орших бөгөөд хамгийн өндөр нь юм. Цайвар шаргал өнгийн боржин чулуугаар хийсэн ба орой хэсгээр нарийн зураасаар толгойн боолт, 3 ширхэг ташуу зураас, дугуй хэлбэрийн хүзүүний зүүлт, унжлагатай цагариг ээмэг дүрсэлсэн ба эдгээрийн доод талаар хээ чимэглэлгүй нарийн зураасан бүс сийлжээ. Нүүрэн талд бүснээс бөмбөлөг толгтой хутга, хажуу талуудад зээтүү, хоромсоготой хөвчилсөн нум зэргийг зүүсэн байдлаар дүрсэлжээ.

Хөшөөний өндөр 81 см, өргөн 44 см, зузаан 22 см хэмжээтэй (Зураг 5d).

**5-р буган хөшөө:** Хүрэн өнгийн боржин чулуугаар хийсэн ба нүүрэн талд гурван ширхэг ташуу зураас дүрсэлсэн. Хөшөөний өндөр 32 см, өргөн 27 см, зузаан 17 см хэмжээтэй. Тус буган хөшөөний урд талд зэрэгцэн байрлах 1 ширхэг дүрслэлгүй хөшөө чулуу бий. (Зураг 5e).

**6-р буган хөшөө:** Энд орших буган хөшөөдийн хамгийн урд захад байрлана. Улаан хүрэн өнгийн боржин чулуугаар хийсэн ба нүүрэн талд хоёр ширхэг ташуу зураас дүрсэлсэн. Хөшөөний өндөр 25 см, өргөн 20 см, зузаан 20 см хэмжээтэй. (Зураг 5f).

**Ивгээл - II хиргисүүрийн буган хөшөө:** Ивгээлийн 1-р буган хөшөөнөөс баруун зүгт 1 км орчим зайд хиргисүүрийн хүрэн дотор нэгэн буган хөшөө газарт булагдсан байдалтай байна. Тус хиргисүүр нь 7 ширхэг цагариг хэлбэрийн дагуул байгууламжтай.

**7-р буган хөшөө:** Тус буган хөшөөг цайвар шаргал өнгийн боржин чулуугаар хийсэн бөгөөд хөшөөний орой хэсэгт тойруулан толгойн боолт, нүүрэн талд гурван ташуу зураас, зууван дугуй хэлбэрийн хүзүүний зүүлт, хажуу талуудад унжлагатай цагариг ээмэг, хоромсого, зээтүү зэргийг тус тус дүрсэлжээ. Хөшөөний газарт булагдсан байсан хэсгийг эргүүлж харахад ташуу зураас, хүзүүний зүүлт, хоромсого зэргийг улаан зосоор будсан ул мөр үлдсэн байв. Хөшөөний өндөр 113 см, өргөн 35 см, зузаан 36 см хэмжээтэй (Зураг 5g).

**Ивгээл - III хиргисүүрийн буган хөшөөд:** 2-р хиргисүүрээс урагш орших дугуй хүрээтэй нэгэн хиргисүүрийн зүүн урд талд эгнүүлэн зоосон 5 буган хөшөө байна. Бид хойд захаас нь эхлэн үргэлжлүүлэн дугаарлаж бүртгэв.

**8-р буган хөшөө:** Тус буган хөшөө нь энд орших хөшөөдийн хойд захад орших ба дээд хэсгээрээ хугарч алга болжээ. Хөшөөний хадгалагдаж үлдсэн суурь хэсэгт бүснээс зээтүү зүүсэн байдлаар дүрсэлжээ. Хөшөөний өндөр 34 см, өргөн 46 см, зузаан 18 см хэмжээтэй (Зураг 6a).

**9-р буган хөшөө:** Цайвар шаргал өнгийн боржин чулуугаар хийсэн ба нүүрэн талд гурван ташуу зураас, орой хэсгээр тойруулан толгойн боолт дүрсэлжээ. Хөшөөний өндөр 53 см, өргөн 35 см, зузаан 25 см хэмжээтэй (Зураг 6b).

**10-р буган хөшөө:** Улаан өнгийн боржин чулуугаар хийсэн ба нүүрэн талд гурван ташуу зураас, доод хэсгээр нарийн зураасан бүс дүрсэлжээ. Хөшөөний өндөр 22 см, өргөн 34 см, зузаан 20 см хэмжээтэй (Зураг 6c).

**11-р буган хөшөө:** Цайвар шаргал өнгийн боржин чулуугаар хийсэн ба нүүрэн талд гурван ташуу зураас, нарийн зураасаар бүс дүрсэлжээ.

Хөшөөний өндөр 31 см, өргөн 28 см, зузаан 21 см хэмжээтэй (Зураг 6d).

**Хөшөөтийн буган хөшөө:** Увс аймгийн Хяргас сумын нутаг Хөшөөт хэмээх газарт 400 х 400 см хэмжээтэй, дөрвөлжин хэлбэрийн хашлага бүхий тахилын байгууламжийн хажууд унасан байдалтай нэг хүн чулуу байна. Дүрслэлийн байдлыг ажиглавал хүн чулуун хөшөөний доод хэсэгт буган хөшөөний гурван ширхэг ташуу зураас, дугуй хэлбэрийн хүзүүний зүүлт, цагариг ээмэг, доод хэсэгт нарийн зураасан бүс зэрэг тус тус мэдэгдэнэ. Хөшөөний өндөр 228 см, өргөн 50 см, зузаан 20 см (Зураг 7).

#### **Буган хөшөөдийн тархалт, төрөл зүйл болон дүрслэлийн онцлог**

Монгол орны баруун бүс нутаг дахь буган хөшөөд нь Монгол Алтайн нурууны салбар уулсын дундах томоохон голуудын хөндий бэлээр ихэвчлэн тархсан байдаг. Үүнтэй нэгэн адил Увс аймгийн нутагт бүртгэгдсэн буган хөшөөд нь баруун хэсэгт Ховд голын хөндий, Их нууруудын хотгор, Хархираа Түргэний уулс, зүүн хэсэгт Хан хөхийн нурууны ар, өвөр бэлээр хамгийн өргөн тархжээ. Бидний энэ удаад өгүүлэн буй буган хөшөөд нь дээрх бүс нутагт хамаарах бөгөөд Увс аймгийн Малчин, Өмнөговь, Сагил, Тариалан, Ховд, Хяргас зэрэг сумдын нутагт орших 9 дурсгалт газарт нийт 21 буган хөшөөд байна. Үүнээс ихэнх буган хөшөөд ганц нэгээрээ орших бол зөвхөн Ховд сумын Ивгээлд ойролцоо 3 хэсэг газарт хиргисүүрүүдийн зүүн талд 11 тооны буган хөшөө байгаа нь цогцолбор дурсгалын төрөлд хамаарна. Ивгээлийн хиргисүүр, буган хөшөөний цогцолбор дурсгалаас гадна Бөхмөрөн сумын Баадайн аманд 5, Зүүнхангай сумын Хүрдлэгийн аманд 8, Бүлцэнгийн үзүүрт 4 буган хөшөөтэй цогцолбор дурсгалууд өмнө нь бүртгэгдсэн байдаг. Мөн Хөтөл нуурын Өндөр мөргөн, Халхайтын дэнжийн 2-р буган хөшөөд нь дугуй хүрээтэй хиргисүүрийн овоолго чулууны зүүн урд талд, Хусны эхийн буган хөшөө хиргисүүрийн голын овоолго чулуун дээр, Шивэрийн үүдний буган хөшөө нь хиргисүүрийн хүрээ чулууны зүүн урд талд тус тус газарт унасан байдалтай оршиж байгаа нь Монголын баруун бүс нутагт түгээмэл, төв, хойд бүс нутагт цөөн тоогоор тохиолдох буган хөшөөт дурсгалын нэгэн бүтэц юм [Баярсайхан 2017: 28-29]. Одоогоор Увс аймгийн Баруунтуруун сумын Баруунтурууны хиймэл нуур, Бөхмөрөн сумын Наран хөдөө, Зүүнхангай сумын Бүлцэнгийн үзүүр, Өмнөговь сумын Бор хаг, Бэлчир, Өндөрхангай сумын Цалуу, Баруун дэнж, Түргэн сумын Хар толгой зэрэг 8 дурсгалт газарт буган хөшөө хиргисүүртэй хамт оршиж байна [Баярхүү, Энхбаяр 2021: 78].

Буган хөшөөг дараа үеийн нүүдэлчид өөрсдийн булш оршуулга, тахилын байгууламжид засаж янзланбэлэн материал болгон ашигласан тохиолдол олонтоо бүртгэгджээ. Бидний илрүүлсэн буган хөшөөдөөс 5 дурсгалт газарт анхны байрлалаараа буюу хиргисүүртэй хамт оршиж байгаа бол Хөх харгайтын буган хөшөөг Чандмань-Сагилын булшны хүрээ чулуунд босгосон, Цалгарын буган хөшөөг Түрэгийн тахилын байгууламжид хашлага болгон хийсэн байна. Мөн Хөшөөтийн буган хөшөө, Цорготын сай, Халхайтын дэнжийн 1, 3-р буган хөшөөг Түрэгийн тахилын байгууламжид хүн чулуу болон хөшөө чулуу болгон зоожээ.

Бидний судалгааны эргэлтэд шинээр оруулж буй эдгээр буган хөшөөд нь бүгд амьтны дүрслэлгүй буюу Евроази төрлийн буган хөшөөд юм. Одоогийн байдлаар энэ төрөлд хамаарах нийт 448 (36,1%) буган хөшөө бүртгэгдсэн ба үүнээс Увс аймгийн нутагт 35 ширхэг бий [Гантулга 2021: 35] хэмээн тэмдэглэгдсэн байдаг. Увс аймгийн нутагт бүртгэгдээд байсан буган хөшөөд (54) дээр 2022 онд илрүүлсэн буган хөшөөдийг нэмж тооцвол нийт 75 болох бөгөөд үүнээс хамгийн их нь буюу Евроази төрлийн 56 (74,6%) буган хөшөө байна.

Эдгээр 21 тооны буган хөшөөд нь дүрслэлийн хувьд уг соёлын хүрээнд дэх түгээмэл зүй тогтол, дүр дүрслэлүүдээс онцгой содон зүйлгүй боловч цөөн тооны онцлогийг зориуд цохон дурдууштай. Тухайлбал, 17 тооны хөшөөнд хүний нүүрийг илэрхийлсэн гурван ширхэг ташуу зураас, Халхайтын дэнж-3, Ивгээл-6 гэсэн 2 хөшөөнд хоёр ширхэг ташуу зураас тус тус сийлсэн бол Халхайтын дэнж-1, Ивгээл-8 зэрэг газрын буган хөшөөд орой хэсгээрээ хугарсан, Шивэрийн үүдний буган хөшөө газарт булагдсан учир тодорхойлох боломжгүй байв. Ерөнхийдөө ихэнх Евроази төрлийн хөшөөнд ташуу зураас сийлсэн дүрслэлийн нийтлэг шинж мөн тус бүс нутагт ажиглагдаж байна. Үүнээс гадна Цалгар, Өндөр мөргөн, Ивгээлийн 4, 7, 9-р буган хөшөө, Халхайтын дэнжийн 1-р буган хөшөө, Шивэрийн үүдний буган хөшөөдийн орой хэсэгт өргөн ховил бүхий толгойн боолт гаргажээ. Энэхүү ховилыг судлаачид толгойн боолт, титэм, малгай хэмээн үздэг [Савинов 1994: 49; Волков 2002: 17; Төрбат нар 2011: 43; Баярсайхан 2017: 139].

Ивгээлийн 7-р буган хөшөөний ташуу зураас, хүзүүний зүүлтийн зарим хэсэг, хоромсого зэргийг улаан зосоор будсан ул мөр хадгалагдан үлджээ. Уг хөшөө нь дугуй хүрээтэй хиргисүүрийн голын овоолго чулууны зүүн талд газарт унасан байдалтай оршиж байсан бөгөөд магадгүй эрт цагт унаж булагдсан учир зосон будаг сайтар хадгалагдаж үлдэх үндэс болжээ. Одоогийн байдлаар манай улсын нутгаас зосон будгийн үлдэгдэл бүхий буган хөшөө Архангай (10), Баян-

Өлгий (1), Булган (5), Өвөрхангай (3), Увс (1), Ховд (8), Хөвсгөл (5) аймгийн нутгаас нийт 33 хөшөө илэрсний дотор Увс аймгийн Зүүнхангай сумын Бүлцэнгийн үзүүрийн 1-р хөшөөний буга, хандгайн (?) дүрсийг зосоор будсан хэмээн тэмдэглэсэн байна [Гантулга 2021: 97]. Ивгээлийн 7-р буган хөшөөний нүүрэн талын ташуу гурван зураасны дээд болон доод зураасыг зосоор будаж голын дүрсийг үлдээсэн нь өвөрмөц юм. Зосны улаан өнгөөр цусыг илэрхийлэхээс гадна мөн хуучин цагийн оршуулгын ёсонд хүний яснаа улаан шунх, зосын зүйл түрхсэн байдаг нь даруй “амилуулах” утга мөн хэмээн тайлбарласан байдаг [Дулам 2000: 50].

Бүс нь эртний нүүдэлчдийн нийгэмд эзлэх байр суурь болон зэрэг дэвийг илтгэх чухал бэлгэ тэмдэг болохын хувьд ихэд хүндэтгэн дээдэлж ирсэн талаар археологи болон түүхийн олон эх сурвалжаас харж болно [Баярсайхан 2017: 162]. Увс аймгийн нутгаас илрүүлсэн дээрх буган хөшөөдийн дотроос Халхайтын дэнж-1, Ивгээл-8, 9, 10, Шивэрийн үүд, Хөшөөт зэрэг нийт 6 хөшөөнд ямар нэг хээ чимэглэлгүй нарийн зураасан бүс дүрсэлжээ. Бүснээс нум, хоромсог, хутга, зээтүү зэрэг зэр зэвсгийн дүрслэл зүүсэн байгаа нь бусад төрлийн буган хөшөөдөөс онцын ялгаагүй ижил болно.

#### Товч дүгнэлт

Эртний нүүдэлчдийн археологийн судалгааны нэгэн чухал эх сурвалж болох буган хөшөөний судалгаа эрчимжихийн хэрээр тус дурсгалын тархалт, үүрэг зориулалт, он цаг, дүрслэлийн утга бэлгэдлийн тухай ойлголтууд улам тодорхой болсоор байна. Увс аймгийн нутгаас илрүүлсэн Евроази төрлийн 21 тооны буган хөшөөг судалгааны эргэлтэд оруулснаар өмнөх судалгааны хэрэглэгдэхүүнийг баяжуулж, зарим онцлог дүрслэлүүдийг дэлгэрүүлэн авч үзэв. Ивгээлийн хиргисүүр, буган хөшөө нь тус бүс нутгаас илэрсэн цогцолбор дурсгал болохын зэрэгцээ судалгааны хувьд өндөр ач холбогдолтой. Энд 3 хиргисүүрт нийт 11 тооны буган хөшөө орших бөгөөд буган хөшөөдийг хиргисүүрийн зүүн талд босгосон ба 1-р хиргисүүрийн 7 хөшөөний 6 нь буган хөшөө нь юм. Эдгээр хөшөөдийн голд босгосон 4-р буган хөшөө нь бусдаасаа харьцангуй өндөр, дүрслэлийн хувьд хамгийн баялаг болохын хувьд харьцангуй илүү өндөр зэрэг дэв бүхий нөлөөтэй хүнд зориулан босгосон байж болно. Харин Ивгээлийн 8-р буган хөшөө нь 2-р хиргисүүрийн зүүн талд ганцаараа орших бөгөөд дүрслэлийн зарим хэсгийг зосоор будсан нь буган хөшөөний соёлд илрэх өвөрмөц тохиолдлын нэг юм. Нийт илрүүлсэн хөшөөдийн дотроос 15 буган хөшөө нь хиргисүүрийн ойролцоо оршиж байгаа нь

Монгол Алтайн нурууны бүс нутагт түгээмэл тохиолдох байршил бөгөөд бусад 6 хөшөөг хожим булш оршуулга болон тахилын байгууламжид ашиглажээ. Эдгээрийн дотроос Хөшөөт болон Халхайтын дэнжийн 3-р буган хөшөөг Түрэгийн хүн чулуу болгон нэмж сийлсэн бол Цорготын сай болон Халхайтын дэнжийн 1-р буган хөшөөг Түрэгийн тахилын байгууламжийн өмнө хөшөө чулуу болгон босгосон нь хүн чулууны төлөөлөл болгосон бололтой.

Өгүүлэл хүлээн авсан: 2023 оны 03 сарын 31

Өгүүлэл засварласан: 2023 оны 04 сарын 17

Өгүүлэл хэвлэгдсэн: 2023 оны 6 сарын 30

### Ном зүй

**Анхбаяр 2005** – Анхбаяр Д. Буган чулуун хөшөөн дэх дүрслэлүүдийн утга зүйн асуудалд. //Түүх, археологи, соёл. Улаанбаатарын их сургуулийн Нийгмийн ухааны факультетын эрдэм шинжилгээний бичиг. Улаанбаатар. 2005.

**Баярсайхан 2015** – Баярсайхан Ж. Баруун монголын нутаг дахь зарим буган хөшөөд. // Нүүдэлчдийн өв судлал. Tomus XVI., Fas.1-34. Улаанбаатар. 2015.

**Баярсайхан, Буян-Орших 2016** – Баярсайхан Ж., Буян-Орших Б. Увс аймгийн Өмнөговь сумын нутаг дахь зарим буган хөшөөд. // Нүүдэлчдийн өв судлал. Tomus XVII., Fas.1-27. Улаанбаатар. 2016.

**Баярсайхан 2017** – Баярсайхан.Ж. Монголын умард нутгийн буган хөшөөд. Улаанбаатар. 2017.

**Баярхүү, Энхбаяр 2021** – Баярхүү Н., Энхбаяр Г. Увс аймгийн буган хөшөөд. - Монгол ба бүс нутгийн буган хөшөөний соёл. Ред. Ц.Төрбат, Боть II, Улаанбаатар, 2021.

**Волков 2002** - Волков В.В. Оленные камни Монголии. Москва., 2002.

**Гантулга 2021** – Гантулга Ж. Буган хөшөөний ангилал. - Монгол ба бүс нутгийн буган хөшөөний соёл. Ред. Ц.Төрбат, Боть III, Улаанбаатар, 2021

**Дулам 2000** - Дулам С. Монголын бэлгэдэл зүй. II дэвтэр: өнгөний бэлгэдэл зүй, зүг чигийн бэлгэдэл зүй. Улаанбаатар, 2000.

**Нямбат, Одбаатар 2010** – Нямбат Н., Одбаатар Ц. Зүүнхангай сумын нутгаас шинээр илүүлсэн буган хөшөө. // Нүүдэлчдийн өв судлал. Tomus X., Fas. 4. Улаанбаатар, 2010.

**Савинов 1994** – Савинов Д.Г. Оленные камни в культуре кочевников Евразии. СПб, 1994.

**Төрбат нар. 2011** – Төрбат Ц., Баярсайхан Ж., Батсүх Д., Баярхүү Н. Жаргалантын амны буган хөшөөд.Улаанбаатар, 2011.


**Цэвээндорж, Энхбат 1989** – Цэвээндорж Д., Энхбат Б. 1989. Увс аймгийн археологийн дурсгалын зураг зохиох шинжилгээний ангийн тайлан. // Монголын археологи: Хээрийн судалгааны тайлан 1987-1989. Боть VIII. Улаанбаатар, 2016.

**Энхбат 1990** – Энхбат Б. Увс аймгийн нутгаар хийсэн археологийн ажлын тайлан. // Монголын археологи: Хээрийн судалгааны тайлан 1990-1991. Боть IX. Улаанбаатар, 2021.


**Эрэгзэн нар 2022** – Эрэгзэн Г., Эрдэнэ-Очир Н., Анхбаяр Б., Батбаяр Т., Эрдэнэболд Л., Амгалантөгс Ц., Эрдэнэ Б., Батболд Г., Цэнгүүн Г., Буян-Орших Б., Алтаншагай М., Бямба-Эрдэнэ Ц., Түвшин Э., Нямхүү М. Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслийн тусгай хэрэгцээний талбай: Увс аймгийн Өмнөговь сумын нутагт хийсэн археологийн авран хамгаалах хайгуул судалгааны тайлан. АХНС. Улаанбаатар, 2022



Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.



Зураг 1. Увс аймгийн нутгаас илрүүлсэн буган хөшөөдийн тархалт



Зураг 2. а. Цалгар, б. Өндөр мөргөн, с. Хөх харгайт-V, d. Халхайтын дэнж-1, e. Халхайтын дэнж-2, f. Халхайтын дэнж-3





а




б

Зураг 3. а. Цорготын сай, б. Шивэрийн үүдийн хиргисүүр, буган хөшөө




Зураг 4. Хусны эхийн хиргисүүр, буган хөшөө




Зураг 5. Ивгээл - I, II хиргисүүрийн буган хөшөөд





Зураг 5. Ивгээл - I, II хиргисүүрийн буган хөшөөд



Зураг 6. Хөшөөтийн тахилын онгон болон буган хөшөөгөөр хийсэн хүн чулуу